

**МОНГОЛ ХЭЛНИЙ ХҮНИЙГ ТАНИН МЭДСЭН УТГАТ  
ДАГАВРЫН ТУХАЙ**

**Д.Бадамдорж \***

Монгол хэлний дагавар бүтээврийн бүтэц, байрлал, утга, үүргийн талаар монголч эрдэмтэд нэлээд судалсан байна. Гэсэн хэдий ч, дагавар бүтээврийг утгаар нь зүйлчилсэн судалгаа өдгөө хүртэл хомс тул үүсмэл үгийн утгыг мэдэх, шинээр нэр томъёо зохиох, дагаврын олон утгыг онож хэрэглэхэд гүнзгийрсэн шинжилгээ чухал байна. Эл зорилгоор монгол хүн судлалд ихээхэн холбогдолтой, монгол хүнийг танин мэдэж, хэрэглэж хэвшсэн, хэсэг бүлэг үг бүтээх дагаврыг түүн шүүн сурвалжилж, түүний байрлал, бүтэц, утга зэргийг нарийвчлан, тус өгүүллийг бичлээ.

Монголчууд өөрийгөө буюу монгол хүний гадаад төрх байдал, дотоод мөс чанар, зан төрх зэргийг сайтар танин мэдсэн болох нь тэдний бичгийн хийгээд аман зохиолоос тандан үзвээс, зарим талаар тодорхой харагдаж байна. Нэгэн жишээг эш болгоё. “Монголын Нууц Товчоо” зохиолын 62 дугаар зүйлд “Дэй сэцэн өгүүлэрүүн: Энэ хөвгүүн чинь “Нүдэндээ галт, Нүүрэндээ гэрээт хөвгүүн буй.” (8:36) хэмээн хэлсний “галт, гэрээт” гэсэн нь есөн настай Тэмүүжинг бараг л харангуут танин мэдэж, нүдэнд дулаан, цовоо сэргэлэн хүү болохыг магтан хэлсэн билээ. Бас “Бум-Эрдэнэ” туульд Төвжаргал хаан Бум-Эрдэнийг ихэд ажиглаж байгаад, “Нүүртээн галтай, Нүүрэндээн цогтой хэнз балчир минь...” (6:74) гэж хэлдэг. Энэ хоёр жишээнд буй -т, -тай| -той| дагавартай үгс монгол хүний шинжийг илэрхийлсэн утгатай болж ирж байна.

Монгол ардын аман зохиол, хэвшмэл хэлцийн дотор хүний мөс чанар, зан төлөвийн тухай утга илтгэсэн тогтсон хэллэг үлэмж бий. Жишээ нь:

“Хүнийг мэдье гэвэл занг нь шинж,

Хүүхдийг мэдье гэвэл тоглоомыг нь шинж.

“Нутаг нутгийн зан өөр

Нуга нугын өвс өөр...( 12 : 182 )

“Хүний сайныг ханилан байж мэднэ,

Хүлгийн сайныг унан байж мэднэ” хэмээн монгол хүний зан төрх, зан ааль, зан байдлыг гярхай ажиглаж, танин мэдээд, цөөн үгээр онож хэлсэн байдаг. Энэ нь монгол хүн судлалын чухал асуудал мөн бөгөөд хүн судлаач, хэл шинжээч нар хамтран судалмаар, нэн анхаарууштай судлагдахуун юм.

Монгол хүний зан байдал, мөс чанар, шинж төлөв (өгөөмөр, баяр хөөртэй, хашир догь, дуулгавартай, эрхлэх, ховч, гэнэн, ичих, эмээх, чалчих, янших, зөрүүд, гэжүүд,

\* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Хэл шинжлэлийн тэнхим

айх, ширвээтэх, хэрүүлч, харам, атах, жөтөх, хөнгөмсөг, сониучирхах, заных, зэвүүцэх, залилах, мэхлэх, зусардах, ховдог, шунахай, ихэрхэг, уур, омог, мөс чанаргүй, дотно гэх мэт 2:131-133) зэргийг өвөрмөц хэлцээс ажиглан мэдэж болно. Монгол өвөрмөц хэлцийн утга нь хүний зан аашийг илэрхийлсэн утгатай ч байдаг гэсэн үг. Тухайлбал, “Алтан амтай, алтан хошуу өргөх, ам алдах, ам булаалдах, ам гарах, ам задгай, ам муруйх, ам муудах, ам мэдэн ярих, ам нээх, ам өгөх, ам сайн, ам таглах, ам түргэн, ам хаах, ам халах, ам хамраа долоох, ам хамхилгүй, ам харах, ам хатуу, ам хуурай байхгүй, ам хэл нь гүйцэгдэхгүй, ам хэл сугалах шахах, ам хэлээ билүүдэх, ам хэлээ олох...” (1:16-23) гэх мэт.

Академич П.Хорлоо “*Ардын хүнлэг ухаан нь хүнийг гадаад төрх ба дотоод сэтгэлээр нь таниулахад чиглэгдэнэ.*” (15:194) гэсэнчилэн, хүний шинжийг илэрхийлдэг дагаврууд ч үүнтэй холбоотой байна. Жишээлэхэд, монгол хэлний -уур (-үүр) дагавар бол үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний зан төрх, зан төлөв, ааш зангийн сайн саарыг үзүүлсэн утгатай тэмдэг нэр үүсгэж, хэрэглээ нь их давтамжтай болжээ. Гол төлөв сээтэгнүүр, алцагануур, гэдэгнүүр, далдагануур, бавчуур, долигонуур, гялалзуур, хувьсгануур, дүүхэлзүүр, годгонуур, жарвагануур, танхилзуур... гэх мэтээр ихэд нарийвчилбал, хүний маш олон ааш аяг, зан авираас жаахан тааруу найруу занг эл дагавраар илтгэдэг ажээ.

Академич Шадавын Лувсанвандан 60 гаруй жилийн тэртээ “*Манай хэл болбоос манай сэтгэлгээ лүгээ маш нягт холбоотой бөгөөд хэл ба түүний хуулийг судлах явдал болбоос өөрсдийн сэтгэлгээний лабортори дор орсон лугаа адил буюу*” (9:02) хэмээн сэтгэн дүгнэж байжээ. Энэхүү судалгааны арга зүй ёсоор монгол хүний зан төлөв, ааш аяг, чанар шинж, төрх байдал зэргийг танин мэдэж, түүнийг илэрхийлсэн утгатай үг бүтээх, утгын нэгэн орон үүсгэх дагавруудыг утгын талаас нь авч үзье.

### Нэг. НЭР ҮГ БҮТЭЭХ ДАГАВАР

Монгол хүний зан төрх, чанар шинж, төлөв байдал зэргийг илэрхийлсэн утгатай жинхэнэ нэр, тэмдэг нэр бүтээх дагаврын тухай өгүүлэе. Үүнд:

1.1. -аа(-ээ, -оо, -өө). Үйл үгийн язгуур, үндсийн дараа байрлаж, тухайн хүний муухан зан ааш, маруухан ааш авир давтагдах утга илэрхийлсэн тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Үглээ (хүний дургүй хүрмээр олон үгтэй, байн байн янших зантай), яншаа, чалчаа, бавнаа, бадчаа, бавтнаа, бахираа, чарлаа, хашгираа, орилоо, мунгинаа, тэвдээ, далдираа, уймраа, онгиороо (Онгиороо хүн, Олонд хүндгүй) гэх мэт. Бас эл дагавар нь үйл үгийн үндсийн хойно байрлаж, жинхэнэ нэр бүтээнэ. Жишээ нь: Атаа, жөтөө, өшөө гэх мэт.

1.2. -аан(-иан, -ээн, -оон, -өөн). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүн олуулаа үйлдэх, дуу чимээтэй, саар зан авир, тэмцэлдэх шинж байдлыг илтгэсэн утгатай жинхэнэ нэр бүтээнэ. Жишээ нь: -Шуугиан (олон хүний дуу гаргах байдал), орилоон, чарлаан, бархираан, хашгираан, бархиралдаан, хөхрөлдөөн, цуугиан гэх мэт. -Тэмцээн (хүмүүс хэсэг хэсгээрээ уралдах нь), уралдаан, зодолдоон, тулалдаан, байлдаан, нанчилдаан, өрсөлдөөн, мэтгэлцээн, зодоон, тулаан гэх мэт.

1.3. -аач(-ээч, -ооч, -өөч). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний зан төрхийн сурамгай, зуршмал шинжийг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Урваач (Ноён урваач, Нохой шарваач), айлгаач, гүтгээч, булзаач, гөрдөөч, завшаач, хэсээч, бусраач, өөлөөч, атаархаач, сайрхаач, “-ээч (человек, профессионально делающий что.л. Мэхлээч “обманщик” от мэхлэх “обманывать” 7 : 79) гэх мэт.

1.4. -ай (-эй). Идэвхгүй язгуурын дараа байрлаж, хүнийг энхрийлэн өхөөрдсөн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Алдрай (гэнэн хонгор, энхрийлүүштэй нь), энхрий, жулдрай, нярай, булбарай, дудрай, дорой, нялзрай гэх мэт. Тухайн үгийн -р гийгүүлэгчтэй нийлж, -рай(-рэй, -рой) гэсэн хубилбар үүсгэнэ.

1.5. -вар(-вэр, -вор, -вөр). Идэвхгүй язгуурын дараа байрлаж, хүний маруухан зан аашийг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Айвар (чалчих, их ярих зантай), хөдвөр (ёс журам төдий л мэдэхгүй хүн), айма|раймхай| гэх мэт.

1.6. -втар(-втэр, -втор, -втөр). Тэмдэг нэр үндсийн дараа байрлаж, тухайн хүний байр байдал, шинж байдлын утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Дөлгөөвтөр (дөлгөөн шинж, зан төрхтэй), аальгүйвтэр, зальтайвтар, настайвтар, залуувтар, хэлэмгийвтэр, шунахайвтар, ичгэвтэр, аанайвтар гэх мэт.

1.7. -г. Жинхэнэ нэрээс үүссэн үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний хүсэхүй, дурлахуй, ханьсахуй, ээнэгшихүй шинж байдал зэргийг илэрхийлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: -Элэгсэг, ижилсэг, цайсаг, хүүхэмсэг, авгайсаг, найзархаг, аагархаг, аавархаг, махсаг гэх мэт. Жинхэнэ нэрээс үүсээгүй үйл үгийн үндсийн дараа байрлаваас, хүний сайн саар шинжийн утгатай тэмдэг нэр үүсгэнэ. Жишээ нь: Сэргэг, залхаг, шунаг, цангаг, залхаг, алхаг, маанаг, зөнөг, тэнэг, гажиг гэх мэт. Бас идэвхгүй язгуурын хойно байрлаж, хүний таагүй занг илтгэсэн утгатай тэмдэг нэр үүсгэнэ. Жишээ нь: Зожиг, хажиг, налиг, нолиг, алиг, шалиг гэх мэт.

1.8. -гч. Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний зан байдал нь зуршин хэвшиж, дадаж мэргэшсэн утгатай цагт нэр бүтээнэ. Жишээ нь: Өглөгч(өглөгч зан, Өнчнийг асарвал, өнөр болдог, Үгүйд тусалбал, өглөгч болдог. Өглөгч хүн, өөртөө хоосон), ачлагч, туслагч, аврагч, загнагч, зусардагч, гайхуулагч, даврагч, завшигч гэх мэт.

1.9. -гай(-гий). Жинхэнэ нэр үндсийн дараа байрлаж, хүний чилээтэй шинж байдлыг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Дуугай, дугай, хэлгий гэх мэт. Энэ нь үгүй гэх үг өргөлтөө алдаж, дагавар болсноос үүссэн бүтээц багатай дагавар юм.

1.10. -гай(-гий, -гой). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, тухайн үйл үгийн утгын дагуу хүний хөдөлгөөний шинжийг заасан утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Наазгай-назгай, гавшгай, хэвцгий, хэрцгий, орсгой, эмсгий, сөдгий гэх мэт.

1.11. -гар(-гэр, -гор, -гөр). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний үйл хөдлөлийн байдлаар янз бүрийн шинж үүссэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Налай-налгар, дүнсгэр, дүмбэгэр, нунжгар, маадгар, маасгар, урвагар, шөвгөр, сээтгэр, хулчгар, хямсгар, жартгар, данагар, пээдгэр гэх мэт.

1.12. -гтай(-гтэй, -гтой). “Нэр үгийн үндсэнд -гтай, -гтой, -гтэй, -гтөй дагавар залгаж, эмэгтэй хүнийг хүндэтгэх жинхэнэ нэр үүсгэнэ.

Хатан + -гтай = хатагтай, эзэн + -гтэй = эзэгтэй, ноён + гтой = ноёгтой “(5: 36-37)

1.13. -гүй. Монгол хэлний үгүй гэх үг өргөлтөө алдаж, хүнд байж болох зан төрхийг үгүйсгэсэн мөртлөө, хүний зан төрхийг үнэлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Аашгүй (элдэв муу ааш зан байхгүй), аальгүй (зан ааш тааруувтар, Аальгүй хүн үгэнд унах, Агсам морь нүхэнд унах) гэх мэт. Бас хүний зан төлөвийг илэрхийлсэн хийгүй, дүрсгүй, зангүй, нүүргүй, овилгогүй, энэрэлгүй, тархигүй, авиргүй, хуншгүй, саваагүй, цөсгүй гэх мэт тэмдэг нэр бүтээнэ.

1.14. -д. Тэмдэг нэр үндсийн дараа байрлаж, ихэвчлэн хүний маруухан шинж байдал, зан төрхийг илтгэсэн тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Зөрүүд, гөжүүд, гажууд, \*этгээд, мугуйд, гаргууд гэх мэт.

1.15. -даг(-дэг, -дог, -дөг). Идэвхгүй язгуурын дараа байрлаж, хүний олдмол муу шинжийн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Ховдог, сувдаг, сарьдаг(тэсвэр муутай, хөнгөн долгин зантай), хохидог (амиа бодогч), \*савдаг (юм бүхэнд оролцож явдаг саваагүй зан), чавдаг (харамч), хайдаг (зуйрган), цэвдэг (хүйтэн сэтгэлтэй) гэх мэт.

1.16. -дай(-дэй, -лдай, -лдэй). Нэр үндсийн дараа байрлаж, хүүхдийг өхөөрдсөн утгатай нэр бүтээнэ. Жишээ нь: Хүүхэлдэй, боролдой, харалдай, шаралдай, салбадай, долдой, долоодой, зургаадай, цагаадай, өгөөдэй гэх мэт.

1.17. -дас(-дэс). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний эмээх ширвээтэх үйлийн үрийн утгатай нэр бүтээнэ. Жишээ нь: Айдас (ямар нэгэн юмнаас түгшин эмээж, сэтгэл санаа тайван бус болсон санагдал, айдас хүйдэс), жигшдэс, ичдэс гэх мэт.

1.18. -жин. Жинхэнэ нэр үндсийн дараа байрлаж, хүний овсгоо сүйхээ, байр байдлыг илтгэсэн тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Зальжин, овжин, сүржин, \*аралжин (олон ааш бүхий) гэх мэт. Эл дагавар бол -жи + -н гэсэн бүтэцтэй нийлмэл дагавар юм.

1.19. -жээр (-жөөр, -шаар). Тэмдэг нэр үндсийн дараа байрлаж, хүний санаа суусан, ахимаг настай байрын шинжтэй болсныг илэрхийлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Ихжээр (нас бага, цус шингэн боловч, ухаан хэрсүү, бие байдал хэвлүү залуу хүний шинж), багашаар (бага залуу), өвгөжөөр (овор ихтэй, өвгөн байрын, нас залуу авч, зан төрх нь өвгөн хүний шинжтэй нь), эмгэжээр (эмгэн байрын, эмгэн шинж байдалтай) гэх мэт. Эл дагавар -ж + -ээр гэсэн нийлмэл дагавар болно.

1.20. -й. Идэвхгүй язгуурын дараа байрлаж, хүний дутмаг шинжийн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Номой, балай (нүдэн балай, чихэн дүлий), элий (элий балай), тулай (хэлэн тулай, хэлгий), дүлий (сонсгол муу) гэх мэт.

1.21. -л. Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний зан чанарын илэрлийг заасан утгатай нэр бүтээнэ. Жишээ нь: Сайрхал, аальгүйрхэл, хийрхэл, бардамнал, солиорол, цэцэрхэл, мөрөөдөл, шунал (шунал ихэдвэл, шулам болно), хүсэл гэх мэт.

1.22. -лаг(-лэг, -лог, -лөг, -лиг). Жинхэнэ нэр, тэмдэг нэр үндсийн дараа байрлаж, хүний зан төрх, чанар шинжийн давуу хийгээд дутмаг байдлыг илэрхийлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Хүнлэг, хүмүүнлэг, хийморлог, хөрслөг, махлаг, иргэнлиг, царайлаг, золбоолог, гоолиг, гуалиг, ядуулаг, бүдүүлэг, намбалаг гэх мэт.

1.23. -лай(-лий, -лой). Нэр идэвхгүй язгуурын дараа байрлаж, хүний өвөрмөц хэтрүү шинжийг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Өөлий (булиа, бадриун биетэй, өсгөлүүн, өөлий хүүхэд), дахлай (дахлай хөх нүүртэй), манлай (Эдэд үл шунагч бол эрийн манлай, Эрдэмд үл бардамнагч бол мэргэний манлай) гэх мэт.

1.24. -лан(-лэн, -лон, -лөн). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний бие, хэл, сэтгэлийн үйлийн үр дүнг заасан утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Баясгалан, сэргэлэн, цатгалан, өлсгөлөн, амгалан, хийсгэлэн, аясгалан гэх мэт.

1.25. -м. Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний хурц зан чанарын утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Бардам (Бардам ам, Шалдан гуя), агсам, харам, өрөвдөм, ялдам (Даага эхдээ ялдам, Дархан дөшиндөө ялдам) гэх мэт.

1.26. -маг(-мэг, -мог, -мөг). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний чадварыг илэрхийлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Шалмаг, чадмаг, шийдмэг, сурмаг, зоримог, бусармаг, хуурмаг гэх мэт. Нэр үгийн үндсийн дараа байрлаж, хүний онцлог шинжийг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Нойрмог, идэрмэг, эрмэг, гүжирмэг гэх мэт.

1.27. -мад (-мэд, -мод). Тэмдэг нэр үндсийн дараа байрлаж, хүний нас, занг илтгэсэн тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Ахмад, эгчмэд, ихмэд, зочмод(зочдыг дайлах хүн), дүүмэд, өчүүхмэд гэх мэт.

1.28. -мал(-мэл, -мол, -мөл). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний олдмол шинжийн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Өргөмөл хүү, буцмал хүүхэн, тэнэмэл гуйлгачин, харимал бөх, будмал хүүхэн гэх мэт.

1.29. -мар(-мэр, -мор, -мөр). Үйл үгийн язгуурын дараа байрлаж, хүний сайн саар зан төрхийг илэрхийлэх утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Зөөмөр (ачаа тээш зөөх дуртай), чалчмар (чалчих нь), хэлмэр (хэлмэр болох), \*аймар (садар самуун, зальхай), \*өгөөмөр (өгөөмөр сэтгэлтэй хүн) гэх мэт.

1.30. -мгай(-мгий, -мгой). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний чадвар, дадлыг илтгэх утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Чадамгай, хэлэмгий долонгой, гүрэмгий, хянамгай, шаламгай, шийдэмгий, сурамгай гэх мэт. Жинхэнэ нэрийн үндсийн дараа байрлаж, хүний эрч хүчтэй шинжийг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Эрэмгий, нүүрэмгий гэх мэт. Эл дагавар -м, -гай гэж задарч болох нийлмэл дагавар юм.

1.31. -мдаг(-мдэг). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний зан төрх, байдал шинж өөрчлөгдсөн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Дүүчлэмдэг (дүүчлэмтгий, дүүч зантай), ичимдэг (нэн ичингүй, ичих зантай), эрэмдэг (эрхэх өвдөх байдалтай, зэрэмдэг) гэх мэт. Мөн нийлмэл дагавар юм.

1.32. -мсаг(-мсэг, -мсог, -мсөг). Тэмдэг нэр үндсийн дараа байрлаж, хүний хүсэх эгээрэх занг илтгэх утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Нялхамсаг, хөнгөмсөг, гангамсаг, хүүхэмсэг, гоёмсог, өөриймсөг гэх мэт. Эл дагавар -м, -с, -г гэсэн бүтэц бүхий нийлмэл дагавар юм. Нялх-м-с-г гэх мэт. Мөн нийлмэл дагавар юм.

1.33. -мтгай(-мтгий, -мтгой). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний үе үе машид дурлан үйлдэх зантайг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Аашламтгай, айлгамтгай, атаархамтгай, гоёмтгой, дагамтгай, мэлзэмтгий (мэлзэх дуртай), гайхууламтгай, аймтгай, гуймтгай, ичимтгий, зочломтгой, зовомтгой, “... Хүн толгойгоо сэгсрэмтгий, сэжимтгий бол хишиг буянаа сэгсрэхтэй адил муу ёр гэдэг.” (14:111) Эл дагавар бол -м, -т, -гай гэж салж болох нийлмэл дагавар юм.

1.34. -мхай(-мхий, -мхой). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний ахин дахин хүсэх эгээрэх, үйлдэх дуртай өөдгүй занг илэрхийлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Дууламхай (Үйлгүй хүүхэн дууламхай, Сүүгүй үнээ мөөрөмхий), гуймхай (Гуймхай мөртлөө голомхой), басамхай (басах зантай), агадамхай, атаархамхай, гайхууламхай, аймхай, ичимхий, булзамхай, мэдэмхий, идэмхий, итгэмхий, мартамхай, тэнэмхий, яарамхай, мэлзэмхий гэх мэт. Мөн нийлмэл дагавар юм.

1.35. -н. Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний зуршмал, ихэвчлэн саар зан аашийг илэрхийлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Хөөргөн (Хөөргөн хүн хөлөө гэмтээнэ, Хөгшин нохой буйлаа гэмтээнэ), зуйрган (Зуйрган хүн, Зулгаа барна), онгиргон, дэвэргэн, цайлган, ховсоргон, хөвсөргөн, харалган гэх мэт. Монгол хэлний хувьсал хөгжлийн явцад үйл үгийн бусдаар үйлдүүлэх хэвийн –га, -гэ, -го, -гө нөхцөл “царцаж”, -н дагавартай нийлмэл байдалтай болж буй хувьсал гарч магадгүй юм. Чингэвээс хөөр- + -гөн =хөөргөн, зуйр- + -ган =зуйрган гэх мэт.

1.36. -нгар(-нгэр, -нгор, -нгир). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний шинж байдал буурмал доройг заасан утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Долингор (догь хашир болсон, хал дол үзсэн), дүйнгэр (дүйнгэ байдалтай), хатангир, хялангар, эцэнгэр

гэх мэт. Эл дагавар бол доли- -нго –р, дүй-нгэ-р, хат-нги-р гэх мэтээр задалж хэлэлцэж болох нийлмэл дагавар юм.

1.37. -нги(-нгэ, -нгө). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний таагүй шинж, байр байдлыг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Зальданги (Зайдан унаа бөгсөнд муу, Зальданги санаа ханшинд муу.), гутранги, ядранги, өжингө, согтонги, халанги, хөгшрөнгө, шунанги, дүйнгэ гэх мэт.

1.38. -нгуй(-нгүй). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний зан байдал илрээд, тогтносон байдлыг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Асрангуй, гайхангуй, бардангуй, аашлангуй, голонгуй, дээрэнгүй, занангуй, өршөөнгүй, энэрэнгүй, догдлонгуй, ичингүй, тачаангуй, хичээнгүй гэх мэт.

1.39. -нхай(-нхий, -нхой). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний шинж байдал, зан төрхийн хувирлыг илэрхийлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Голонхой (голох дуртай болсон), наалинхай, уйланхай, туранхай, эцэнхий, дэрэнхий (хийсгэлэн, дураараа зантай) гэх мэт.

1.40. -нцар(-нцэр, -нцор, -нцөр). Жинхэнэ нэр үндсийн дараа байрлаж, хүний хэтэрсэн шинжийг илэрхийлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Аманцар (амтай, их ярьдаг), хоолонцор, хээнцэр, хүүхэнцэр (хүүхэн мэт ааштай), охинцор (охин байдалтай), үгэнцэр (үгэнд дуртай), \*үхээнц (дорой, -нц дагавар бол энэ дагаврын хувирбар шинжтэй байна) гэх мэт.

1.41. -р. Идэвхгүй язгуурын дараа байрлаж, хүний ааш зангийн утгатай нэр үг бүтээнэ. Жишээ нь: Авир, айдар, адайр, хэдэр (Хэдэр хүн хээр, Хэдрэг мод гадаа), садар гэх мэт.

1.42. -ран(-рэн). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний байн байн үйлдэх үйлийн шинжийг заасан утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Бааран (байн байн өтгөн мөр үзүүлэх), шээрэн (үе үе шингэн мөр үзүүлэх) гэх мэт.

1.43. -т. Ихэвчлэн жинхэнэ нэр үндсийн дараа байрлаж, хүний зан чанар, шинж байдал зэргийг агуулсан утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Ачит (ачит багш), элбэрэлт (элбэрэлт эх), аашит, зальт, авирт, ичгүүрт, галт, гэрээт, гэмт (Гэмт хүн гэлбэлзэнэ, Дайрт морь дайвалзана), хүндэт, сүжигт, өршөөлт, мэхт гэх мэт.

1.44. -тай(-тэй, -той). Жинхэнэ нэр үндсийн дараа байрлаж, хүний зан суртахуун, ёс суртахууны онцлогийг илэрхийлсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Бачтай (Баян хүн бачтай, Ядуу хүн хочтой.), нуруутай, томоотой, аатай, бахтай, хавтай, дуулгавартай, арчаатай, ичгүүртэй, намжиртай, ууртай, хайртай, зантай, үзэсгэлэнтэй, хийтэй, ааштай (Ааштай хүн, Хүндээ барна), хартай "Монгол харын бөөгийн шаашинтны нэг хэсэг нь хараал зүхэл үйлддэг бөгөөд эднийг ХАРТАЙ бөө хэмээн нэрлэдэг" ( 13 : 214) Эл дагавар хэрэглээний давтамж их байна.

1.45. -тан(-тэн, -тон, -төн). Жинхэнэ нэр үндсийн дараа байрлаж, хүний эрдэм ухаан, зан төлөв, ажил үйл, хайр энэрэл зэргийг илтгэсэн утгатай жинхэнэ нэр бүтээнэ. Жишээ нь: Эрдэмтэн, оюутан, сэхээтэн, ачтан, сүсэгтэн, хаантан, хатантан, эзэнтэн, гэгээнтэн, ламтан, багштан, ахайтан, буянтан, ёстон, ялтан, бачтан, буруутан, хэрэгтэн, атаатан гэх мэт.

1.46. -уу(-үү). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний зан суртахууны байдлыг илэрхийлсэн тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Залхуу (Бага залхуугаас их залхуу), нэрэлхүү (Нэрэлхүү хүн хоолгүй, Нарийн хүн нөхөргүй) гэх мэт. Монголын утга зохиолд маш өргөн дэлгэр хэрэгтэй дагавар юм. Үүнд: Даруу, даруудуу, яаруу, давчуу, агсруу, аанайдуу, адгуу, сандруу, бажгадуу, бачимдуу, тэвдүү, бухимдуу, махруу,

махсуу, монголжуу, аавархуу, ааглуу, ааширхуу, дэврүү, хийрхүү, эрдүү, ядуу, зүдүү дотносуу, бүрэгдүү, тахимдуу, тусархуу гэх мэт.

1.47. -уун(-иун, -үүн). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний голдуу даруу бус зан төлөв, зан аашийг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Хөшүүн, гөжүүн, дэврүүн, сэвүүн, алуун халуун, нялуун, шазруун, сэхүүн гэх мэт. Мөн –луун, -лүүн хувилбартай ч байна. Жишээ нь: Хангалуун, хэвлүүн, давлиун, сэхлүүн гэх мэт.

1.48. -уул(-үүл). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, оргох зайлах, харах цагдах зэрэг үйлийг үйлдсэн эзнийг илтгэсэн жинхэнэ нэр бүтээнэ. Жишээ нь: Босуул, зугтуул, зайгуул, хэсүүл, тэнүүл, завхуул, харуул, хэвтүүл, тагнуул, туршуул гэх мэт.

1.49. -уур(-үүр). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний болгоомжит эсвэл хөнгөмсөг зэрэг занг илэрхийлсэн тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Хянуур, няхуур, сээтэгнүүр, гялалзуур, алцагануур, бавчуур, гэдэгнүүр, годгонуур, далбагануур, долигонуур, гөлөлзүүр, хуйсгануур, дүүхэлзүүр, дүрэлзүүр, ангалзуур, жарвагануур, танхилзуур гэх мэт.

1.50. -хай(-хий, -хой). Жинхэнэ нэр ба тэмдэг нэр үндсийн дараа байрлаж, хүний их төлөв маруухан ааш занг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Зальхай, завхай, муухай, заалхай, мануухай, сүрхий гэх мэт. Бас үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний зарим шинж заасан тэмдэг нэр үүсгэнэ. Жишээ нь: Шунахай, халирхай, далдирхай, цагаалхай сэтгэл гэх мэт. Зарим идэвхгүй язгуураас энэ дагавар хүнийг шинжийг заасан тэмдэг нэр үүсгэнэ. Жишээ нь: Гярхай, хомхой, хувхай гэх мэт.

1.51. -хан(-хэн, -хон, -хөн). Тэмдэг нэр үндсийн дараа байрлаж, хүний чанар шинж нэлээд гүн илэрсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Аминчхан, гүдэсхэн, даруухан, залуухан, ануухан, уяхан, номхон (Ааш зангийн номхон нь дээр, Адуу малын тарган нь дээр.) гэх мэт.

1.52. -хуй(-хүй). Үйл үгийн үндсийн дараа байрлаж, хүний оюун санааны үйлийг илэрхийлсэн утгатай цагт нэр бүтээнэ. Жишээ нь: Мэдрэхүй, сэрэхүй, сэтгэхүй, хүртэхүй, асрахүй, энэрэхүй гэх мэт.

1.53. -цаг(-цэг, -цог, -цөг). Жинхэнэ нэр ба идэвхгүй язгуурын дараа байрлаж, хүний дутагдалтай занг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Оронцог (хүний оронцог), долгонцог (сувдаг, бялдууч, ховдог), оорцог (зожиг), хэвцэг (хэдэр), хявцаг (хажиг), төгцөг (хөгширсөн хүн), Гаднаа гяланцаг, дотроо паланцаг гэх мэт.

1.54. -ч. Жинхэнэ нэр ба тэмдэг нэр үндсийн дараа байрлаж, хүний хэвшил зуршил болсон ажил үйл, зан ааш, хүмүүжил төлөвшлийн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Арвич, хямгач, гамч, буянч, үнэнч, атаач, авлигач, бялдууч, заргач, жөтөөч, худалч, хуурамч (Худалч хүний нээрээ олон, Хуурамч хүний хөөрхий олон.), хулгайч (хумсалсаар хумсалсаар хулгайч) гэх мэт.

1.55. -чир(-нчир). Жинхэнэ нэр үндсийн дараа байрлаж, хүний зарим нэгэн шинжийг илтгэсэн утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: Айлчир (айл хэсэх дуртай), аминчир (амиа боддог зантай), хувинчир (хувиа боддог зантай), холчир (тогтворгүй ааш зантай), өлчир (авсаар даарахгүй, өлчир хүүхэд) гэх мэт.

1.56. -шууд. Эр хэмээх үгийн үндсийн дараа байрлаж, хүний эрэмгий, гүдэсхэн зан байдлыг заасан утгатай тэмдэг нэр бүтээнэ. Жишээ нь: “Эх Ханд хүүгийнхээ бор гарыг ажиглан харж, эршүүд гүжирмэг болсныг мэдэв.” | Л. Түдэв “Алтан гадас чигийг заана. | Мөн эршүүн гэж ч хэлдэг.

Монгол туургатаны хэлний үгийн санд монгол хүний зан чанар, шинж байдлыг тодорхойлох утгат дагавартай үгс үлэмж тоотой юм. Тухайлбал, шуна-, шунаач, шунаг,

шунагхан, шунагч, шунал, шуналгүй, шуналт, шуналтай, шуналтан, шунамгай, шунамгайвтар, шунамхай, шунамтгай, шунанги, шунангуй, шунахай, шунахайвтар, шунахайвтардуу гэх мэтээр үүссэн байна. Судалгаанаас үзвэл, өндөр давтамж, хэрэглээ бүхий -аач, -г, -хан, -гч, -л, -гүй, -т, -тай, -тан, -мгай, -втар, -мтгай, -мхай, -нги, -нгуй, -хай, -уу гэх зэрэг дагавар бүртгэгдэж байна.

### Хоёр. ҮЙЛ ҮГ БҮТЭЭХ ДАГАВАР

Монгол хүний ёс суртахууны хүмүүжил, зан суртахууны төлөвшилтэй холбоотой утга илэрхийлсэн, үйл үгийн дагавруудыг товч тоймлон авч үзье. Үүнд:

2.1. -д. Тэмдэг нэрээс хүний зан ааш, шинж байдал зохисгүйдэх тавгүйдэх утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Аальгүйд-, аашгүйд-, ичимхийд-, бухимд-, адгууд-, дүрсгүйд-, зулгүйд-, хөнгөд- гэх мэт.

2.2. -ж. Жинхэнэ нэр ба тэмдэг нэрээс хүний эерэг шинж улмаар төлөвших утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Жавхааж-, аагж-, залууж-, хүмүүж-, хатууж-, зоригж- гэх мэт.

2.3. -й. Идэвхгүй язгуурын дараа байрлаж, хүний ааш аяг, зан төрхийг илэрхийлсэн утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Аадай-, маадай-, архай-, алхай-, нурмай-, зантай-, жартай-, гөлий-, гонсой-, бултай-, дардай-(Булавч, бултайна. Даравч, дардайна.) гэх мэт.

2.4. -л, -ла, -лэ, -ло, -лө. Жинхэнэ нэр ба тэмдэг нэрээс тухайн нэрийн үгийн сангийн утгыг хадгалангаа, хүний зан ааль, шинж чанарыг илэрхийлсэн утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Манлайл-, авирла-, маягла-, адайрла-, аашил-, аагал-, мэхэл-, залил-, долдойл-, уурла-, гавшгайл-, нөхөрлө-, ханил-, найзал- гэх мэт.

2.5. -лз. Үйл үгийн язгуур, үндсийн дараа байрлаж, хүний зан төлөв, ааш зан, байдал шинж зэргийн үйл хөдлөлийг дүрсэлсэн утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Жавхалз-, даналз-, сээтэлз-, дүүхэлз-, гэгэлз-, малилз-, арзалз-, соохолз-, хоохолз-(Сонин дээрээ соохолзох, Сониноо буурахаар хоохолзох.) гэх мэт.

2.6. -на, -нэ, -но, -нө. Нэгэн удаагийн үйлдэл мэдрэгдэх идэвхгүй язгуурын дараа байрлаж, хүний зан байдлын өвөрмөц хөдлөл давтагдахыг илэрхийлсэн утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Маамгана-, саамгана-, аадгана-, алцгана-, арзгана-, жарвагана-, онгогоно-, долгино-, шарвагана- гэх мэт. Эл дагавар бол –гана, -гэнэ, -гоно, -гөнө гэх нийлмэл хувилбартай болдог. Бид эл ниймэл дагаврыг салгаж тайлбарласан юм.

Бас тэмдэг нэрээс хүний зан байдлыг илтгэсэн утгатай үйл үг үүсгэнэ. Жишээ нь: Бардамна-(Бага гэж бүү бас, Баатар гэж бүү бардамна.), агсамна-, харамна- гэх мэт. Мөнхүү жинхэнэ нэрээс хүний зан байдлын өвөрмөц содон хөдлөлийг илэрхийлсэн үйл үг үүсгэнэ. Жишээ нь: Цамна-, замна-, дайсагна-, номно- гэх мэт.

2.7. идэвхигүй р. Тэмдэг нэрээс хүний шинжийг илтгэсэн утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Агсар-, нялуур-, бусар-, завхар-, согтуур-, хөлчүүр-, бачуур-, сагсуур-(Баян гэж бүү сагсуур, Баатар гэж бүү бард.) гэх мэт. Хааяа жинхэнэ нэрээс хүний байдал шинжийг заасан утгатай үйл үг үүсгэнэ. Жишээ нь: Махар-, бэтгэр-, эмгэр-, өвгөр- гэх мэт.

2.8. -рх(-лх). Жинхэнэ нэрээс хүний эзэмдэх зан байдал, зан төрхийг илтгэсэн утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Ааварх-, ахарх-, эгчирх-, атаарх-, барх-, таларх-, найзарх-, гадуурх-, аймгарх-, нутгарх-, хүнийрх-, нэрэлх-, эрэлх-, мэдэхийрх-, бүлэрх- гэх мэт.

2.9. -с. Жинхэнэ нэрээс хүний найрсаг шинжийг илэрхийлсэн утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Ханьс-, нөхөрс-, дотнос-, ижилс-, элэгс-, элгэмс-, эвс-, хүүхэмс- гэх



мэт. Мөн жинхэнэ нэрээс хүний хүсэх дурлах шинж илтгэсэн утгатай үйл үг үүсгэнэ. Жишээ нь: Цайс-, махас-, нойрс-, ундаас- гэх мэт.

2.10. -т. Тэмдэг нэрээс их төлөв хүний бүтэлгүйхэн шинжийг илэрхийлсэн утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Аальгүйт- “Эмэгтэй хүн олны дунд аальгүйтэх, эрээ жолоогүй аашлахыг цээрлэнэ. ...дөлгөөн намуун аашийг эрхэмлэнэ.” ( 14 :151), аат-, аанайт-, аашгүйт-, золигт-, дүрсгүйт-, зөнөгт-, нохойт-, тэнэгт-, мангарт- гэх мэт.

2.11. -ц. Тэмдэг нэрээс хүний зан төрхийн дутагдалтайг илтгэх утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь : Булхайц-, унтууц-, эгдүүц-, адгууц-, мөрийц-, эвгүйц-, арц-, барьц- гэх мэт.

2.12. -чил. Жинхэнэ нэр ба тэмдэг нэрээс хүний зан байдлын сайн саарыг илэрхийлсэн үйл үг бүтээнэ. Жишээ нь: Царайчил-, санаачил-, аминчил-, алагчил-, дотночил-, муучил- гэх мэт.

2.13. -ш. Тэмдэг нэрээс хүний шинж байдал даамжрах лавшрах утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Аанайш-, аагш-, зожигш-, дотнош- гэх мэт. Мөн жинхэнэ нэрээс хүний чадвар нэлээд гүнзгийрч буйг илэрхийлсэн утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Мэргэш-, гарш-, идээш- гэх мэт.

2.14. -шир. Жинхэнэ нэр ба тэмдэг нэрээс хүний санаа байдал лавширч байгааг илтгэсэн утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Бодлогошир-, санаашир-, саймшир-, халшир-, тайвшир- гэх мэт.

2.15. -шаа(-шээ-, -шоо, -шөө). Жинхэнэ нэр хийгээд тэмдэг нэрээс хүний байдлыг хүнээс үнэлэх утгатай үйл үг бүтээнэ. Жишээ нь: Бэлгэшээ-, ойшоо-, таашаа-, сайшаа-, муушаа-, тээршээ-, \*өршөө- гэх мэт.

Монгол хүний шинж чанар, зан байдлыг заасан үйл үгийг -д, -ж, -й, -л, -лз, -на, -р, -рх, -с, -т, -ц, -чил, -ш, -шир гэх мэт дагаврууд үүсгэж байгаа нь бидний ажиглалт судалгаанаас тодорхой байна. Эдгээр үг бүтээх дагавар бүтээвэр бол эрдэмтэн Ж.Лүнтүүгийн “Бодит хэрэг бодисын хүмүүсийн тархин дахь хураангуй тусгал нь үгэнд батажсаныг үгийн утга гэнэ” (10:30) хэмээн тодорхойлсон ёсоор тодорхой байрлалд байршиж, утга зааж байгаа юм.

Монгол хэл шинжлэлд зарим дагаврыг нийлмэл байдлаар тайлбарлаж ирсэн юм. Тухайлбал, “12. Нэр үгийн үндэснээ –рхаг, -рхэг дагавар залгаваас үндсэн үгийн утгын дагуу БАРДАМНАХ байдал бүхий нэр үг үүсмүй. Үлгэрлэвээс баян-баярхаг, эзэн-эзэрхэг, ид-идэрхэг гэх мэт.” (9:147) Бид эл –рхаг, -рхэг нийлмэл дагаврыг аль болох нарийвчлан, нэр ба үйл үг үүсгэхээр нь зааглаж тайлбарласан болно. Жишээ нь: Баян-баярх-баярхаг, эзэн-эзэрх- эзэрхэг гэх мэт.

## ДҮГНЭЛТ

Монгол хэлний үг бүтээх дагаврыг судлах тусам хэлний утга зүйн нарийн ширийн зүйлс ундрэн гарч ирсээр байна. Монгол хүний зан төлөв, шинж чанарыг илэрхийлсэн утга заасан үг бүтээх дагаврууд бол монгол хүнийг зан суртахуун, ёс суртахууны талаас нь сайтар танин мэдсэний онцгой илрэл юм. Бид эл өгүүлэлд нэр үг бүтээж байгаа 56 дагавар, үйл үг бүтээж байгаа 15 дагавар тус бүрийн утгыг товч тайлбарлан товчоолсон юм. Эдгээр үг бүтээх дагаврын утгаар монгол хүний зан төрх, мөс чанарыг нэвтэрхий мэдэж болох бөгөөд ЗАН САЙТЫГ илтгэсэн : эршүүд, арвич, энэрэнгүй, гүдэхэн, гярхай, хянуур, даруу, ачтан, томоотой, зочломтгой, чадамгай, шалмаг, царайлаг,

налгар, элэгсэг гэх мэт, ЗАН МУУТЫГ илтгэсэн: аминчир, худалч, хявцаг, шунахай, сээтэгнүүр, бухимдуу, атаатан, хийтэй, мэдэмхий, хийрхэл, ховдог, хэвцгий, хүүхэмсэг, үглээ гэх мэт үгийн үндэст шигдсэн үг бүтээх дагавар байна.

## НОМЗҮЙ

1. Аким Г. “Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь” УБ. 1982. 16-23 дахь тал.
2. Бадамдорж Д. “Монгол хэлний үгийн сангийн утга зүй” УБ. 2006. 131-133 дахь тал.
3. Болд Л. “Орчин цагийн монгол хэлний тонгоруу толь” УБ. 1976.
4. Болд Л. “Орчин цагийн монгол хэлний дагавар” УБ. 1986.
5. Жагварал Р. “Монгол хэлний хүндэтгэлийн үг” УБ.1976.36-37 дахь тал
6. Kadar L. , Katu B. “Аврагдсан туульс, Rescued Epics” Budapest.2012. pp.74.
7. Крылов С. А. “Теоретическая грамматика современного монгольского языка и смежные проблемы общей лингвистики” Часть 1. Москва. 2004. Стр. 79
8. Ligeti L. “ Histoire secrete des Mongols” Budapest. 1971. 36.
9. Лувсанвандан Ш. “Монгол хэлний зүй” Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. Цуглалт хаалага. 1951. 147 дахь тал.
10. Лүнтүү Ж. “Одоо үеийн монгол хэлний үгсийн сангийн зүй” Гурван дэвтэр, Ланжуу. 1987. 30 дахь тал.
11. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” Таван боть, УБ. 2008
12. “Mongolian Proverbs A window into their word” Janice Raymond, Translated by Otgonjargal O. UB. 2010. Pp. 182
13. Пүрэв О. “Монгол бөөгийн шашны нэр томъёоны тайлбар толь” УБ. 2003. 254 дэх тал.
14. Түдэв Л. “Аман хууль” УБ. 2000. 111, 151 дэх тал.
15. Хорлоо П. “Монгол ардын зан үйлийн хэлхээ” УБ. 1999. 194 дэх тал
16. Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь” УБ. 1966.
17. Шагж С. “Монгол үгсийн дүрмийн толь” Монгол улсын 27 дугаар он.

## SUMMARY

Having studied the derivational suffixes of Mongolian, the more particular semantic meaning of the language has been appearing. In this article, we have explained 56 nominalizing suffixes and 15 suffixes which form verb in detail. From these derivational suffixes, we can know thoroughly the character, temperament and quality of Mongolians such as *determined, economic, sympathetic, insightful, hospitable, masterful and clever* which show positive/good quality and *selfish, fake, greedy, nervous, nattered and voracious* which show negative/bad quality.